



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №42


2018 оны 12-р сарын 24-28

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **1268** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 122(9.6%) галзуугийн эрсдэлд өртсөн, 1099(87%) хачигт халдвар, 25(2%) бэтэг, 2(0.1%) хумхаа, 10(0.7%) боом, 7(0.5%) тарваган тахал, ку чичрэг, татран, денгийн чичрэг өвчний хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол тус тус 1(0.1%) бүртгэгдээд байна.

1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 1099 сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 13.7%-иар, эпидемиологийн 51-р долоо хоногтой харьцуулахад 1 сэжигтэй тохиолдлоор тус тус бага байна.



Хачигт риккетсиозын 818 сэжигтэй тохиолдлын 202(24.7%), хачигт энцефалитын 185 сэжигтэй тохиолдлын 32(17.3%), хачигт боррелиозын 96 сэжигтэй тохиолдлын 23(24.2%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдсан байна


1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 122 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 25%-иар, эпидемиологийн 51-р долоо хоногтой харьцуулахад 2 сэжигтэй тохиолдлоор тус тус бага байна.



1.3 Мэрэгч амьтны сэжигтэй дуудлага:

12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар Нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, БГД, ХУД, СБД, СХД, ЧД)-ээс мэрэгч амьтны нийт 95 дуудлаганд үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс 13.7%-иар илүү байна



ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Шүлхий өвчин: Дорнод, Халгол сум

Дорнод аймгийн Халхгол сумын Ялалт багийн “Дунд шавар” гэдэг газар 12-р сарын 21-ний өдөр малчин “П”-ийн 6 үхэрт мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний шинж тэмдэг илэрсэн тул, дээж авч УМЭАЦТЛ-д шинжлүүлэхэд шүлхий өвчин нь батлагдсан байна. 12 дугаар сарын 26-ны өдрөөс тус сумын Засаг даргын захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоосон. Нийт 10 өрхийн 4551 толгой малыг вакцинжуулж, ариутгал халдваргүйжүүлэлт хийгээд байна.



Эх сурвалж: ОБЕГ


Олон улсад:

Мал, амьтны галзуу өвчин: Малайз

Малайз улсын Мал эмнэлгийн газраас мэдээлснээр 12-р сарын 11-нд Сарабак хотын Кучинг мужид мал, амьтны галзуу өвчин бүртгэгдэж, 17 нохой өртөмхий байснаас, 1 нохой өвчилж үхэн, 2 нохойг устгажээ. Тус хотын Кедахт 277 нохой, Перлист 1864 нохой, Сарабакад 8508 нохой, 98674 мууранд, нийт 109323 гэрийн тэжээвэр амьтанд вакцинжуулалт хийгдсэн байна.

Эбола вирус халдвар:

Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад 12 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар Хойд Киву мужийн 12 эрүүл мэндийн төв, Итури мужийн 3 эрүүл мэндийн төвөөс Эбола вирус халдварын сэжигтэй 549 (501 батлагдсан, 48 болзошгүй) тохиолдол, үүнээс 326 нас баралт бүртгэгдсэн тухай мэдээлжээ.



Эх сурвалж: ДЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

БНХАУ-ын Хөдөө аж ахуйн яамнаас мэдээлснээр 12-р сарын 13-нд Чунцин хотын Бишанд мужийн гахайн аж ахуйд африкийн гахайн мялзан өвчин 23 тохиолдол бүртгэгдсэн ба 3 гахай өвчилж үхэн, 20 гахайг устгасан.



Эх сурвалж: ДАЭМБ

Гахайн сонгомол мялзан өвчин:

Япон улсын Хөдөө аж ахуйн яамнаас мэдээлснээр 12-р сарын 23-нд Гифү хотын Сэки мужийн гахайн аж ахуйд гахайн сонгомол мялзан өвчний 7547 тохиолдол бүртгэгдсэн ба 2 гахай өвчилж, 7547 гахайг устгаж, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна



Эх сурвалж: ДАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

БНХАУ-ын Хөдөө аж ахуйн яамнаас мэдээлснээр 12-р сарын 22-нд Нанфинг хотын Фужиан мужийн гахайн аж ахуйд африкийн гахайн мялзан өвчин бүртгэгдэж, 5776 гахай өртөмхий байснаас, 35 нь өвчилж, 11 гахай өвчилж үхэн, 5765 гахайг устгасан байна. Тус голомтод тандалт судалгаа хийж, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан тухай ДАЭМБ-аас мэдээлжээ.



Эх сурвалж: ДАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

Молдав улсын Хөдөө аж ахуйн яамнаас мэдээлснээр Кахул хотын нэгэн мужийн гахайн аж ахуйд африкийн гахайн мялзан өвчин бүртгэгдэж, 8 гахай өртөмхий байснаас, 4 гахай өвчилж үхэн, 4 гахайг устгасан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Энэ долоо хоногт Архангай, Завхан, Ховд, Төв, Хөвсгөл аймгийн ЗӨСТ-үүд үйл явдалд суурилсан тандалтын мэдээгээ илрүүлсэн байна.

Бусад салбар төвүүд ШУН-ийн доорхи хаяг руу мэдээгээ ирүүлж байна уу?

eop@nczd.gov.mn

nczd.eop@gmail.com

ШУУРХАЙ УДИРДЛАГЫН НЭГЖ